Бодлогын баримт бичгийн хэрэгжилт
захиргааны байгууллагын үйл
ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ
хийх нийтлэг журмын 10б хавсралт

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ОРОН НУТАГТ ТӨЛӨӨЛӨН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДААС ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ХҮРЭЭНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

| Д/д | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Үр дүнгийн үзүүлэлт | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Зарцуулсан хөрөнгө | Шалгуур үзүүлэлт | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт хүрээгүй бол тайлбар |
| 1.4 | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 28 дугаар хуралдааны тэмдэглэлээр тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүн, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгосны дагуу орон нутгийн иргэн, хуулийн этгээдэд тоон гарын үсэг олгох ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх | | ТГҮ олгох Киоск машины тоо | 1 | Бүртгэлийн үйлчилгээний КИОСК машин 1ш, зөөврийн 4жи төхөөрөмж 1ш тус тус шийдвэрлэн сүлжээнд холбож хэвийн ажиллуулж байна. Зөөврийн төхөөрөмж ашиглан аймгийн 15 сумын Иргэдээ сонсьё өдөрлөгт олон нийтийн арга хэмжээнд оролцож 2 албан хаагчийн томилолт унааны зардлыг аймгийн ЗДТГазар шийдвэрлэж хамтран ажиллалаа.<br>Иргэдэд тоон гарын үсэг олгох ажлын хүрээнд тус аймгийн хэмжээнд 2023 гарсаар **2472** иргэнд тоон гарын үсэг олгосон байна.<br>Аймгийн хэмжээнд нийт 32044 иргэнд тоон гарын үсэг олгохоос **14473** иргэн буюу **45,1** хувьд олгоод байна. Тоон гарын үсгийг **12780** иргэнд иргэний үнэмлэхийн чипэнд, **1693** иргэнд гар |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | утасны gsign апплекейшнаар дамжуулан олголоо. Улсын бүртгэлийн ерөнхий газар, ХААН банкны хамтын ажиллагааны хүрээнд ‘’Тоон гарын үсэг олголтыг идэвхжүүлэх аян’ –г 2023 оны 04 сарын 3-ны өдрөөс 2023 оны 06 сарын 30 хүртэл зарлан тоон гарын үсэг олголтыг идэвхжүүлэх, иргэдийн тоон гарын үсгийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулж байна. Энэ ажлын хүрээнд ХААН банкин дээр үйлчлүүлж байгаа иргэдэд 4 жи төхөөрөмжийг ашиглан тоон гарын үсэг олгож ажлыг 3 хоног зохион байгуулсан. 4 дүгээр сард 682 иргэнд тоон гарын үсэг олголоо.<br>Мөн иргэд бүртгэлийн ажилтанд хандалгүй Аймгийн тамгын газрын цахим үйлчилгээний хэсэгт байрлах бүртгэлийн үйлчилгээний киоск машинд хандан тоон гарын үсэг авах боломжтой болсон.. |

# Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

## Улсын бүртгэлийн хэлтэс

**2023 оны 5 сар**

| Шийдвэр Д/д | Заалт Д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | Хэрэгжилтын явц | Өөрийн үнэлгээ | Дээд шатны байгууллын үнэлгээ | Үнэлгээний тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| **ЗГ-ын хуралдааны тэмдэглэл** | | | | | | | |
| 10 | 16 | 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл<br>2022-05-11<br>Дугаар 2022_28 | XX.7. Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд, тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн | Иргэдэд тоон гарын үсэг олгох ажлын хүрээнд тус аймгийн хэмжээнд 2023 гарсаар **2472** иргэнд тоон гарын үсэг олгосон байна.<br><br>Аймгийн хэмжээнд нийт 32044 иргэнд тоон гарын үсэг олгохоос **14473** иргэн буюу **45,1** хувьд олгоод байна. Тоон гарын үсгийг **12780** иргэнд иргэний үнэмлэхийн чипэнд, **1693** иргэнд гар утасны gsign апплекейшнаар дамжуулан олголоо. Улсын бүртгэлийн ерөнхий газар, ХААН банкны хамтын ажиллагааны хүрээнд ''Тоон гарын үсэг олголтыг идэвхжүүлэх аян' –г 2023 оны 04 сарын 3-ны өдрөөс 2023 оны 06 сарын 30 хүртэл зарлан тоон гарын үсэг олголтыг идэвхжүүлэх, иргэдийн тоон гарын үсгийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулж | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | болон төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгов. | байна. Энэ ажлын хүрээнд ХААН банкин дээр үйлчлүүлж байгаа иргэдэд 4 жи төхөөрөмжийг ашиглан тоон гарын үсэг олгож ажлыг 3 хоног зохион байгуулсан. 4 дүгээр сард 682 иргэнд тоон гарын үсэг олголоо.<br><br>Мөн иргэд бүртгэлийн ажилтанд хандалгүй Аймгийн тамгын газрын цахим үйлчилгээний хэсэгт байрлах бүртгэлийн үйлчилгээний киоск машинд хандан тоон гарын үсэг авах боломжтой болсон. | | | |
| **Ерөнхийлөгчийн зарлиг** | | | | | | | |
| 1 | 29 | Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туай 2018-05-23 Дугаар 2018_46 | 3.. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай. | Албан хаагчдын хаалганы хаяг, мэдээллийн самбар, хувийн хэрэг зэргийг кирилл монгол хосолсон бичгээр албан тушаал, нэрийг бичиж байршуулсан. Дунд шатанд 12 албан хаагч, ахисан шатанд 3 албан хаагч болзлыг хангасан байгаа бөгөөд эдгээр албан хаагчид өөрсдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх үүднээс бататгал хичээлийг Бичиг хэргийн ажилтан Д.Наранцэцэг зохион байгуулж эхлээд байна. ”Хүмүүн бичиг” сонинг жил бүр захиалан өөрсдийн мэдлэгийг дээшлүүлэхэд гарын авлага болгон уншицгааж байна.Төрийн албан хаагчдын Монгол бичгийн | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | олимпиадад Дарга Ж.Өлзийжаргал ахлах бүртгэгч Б.Сайхантуяа нар оролцсон. | | | |
| | 30 | | 4. Энэхүү зарлигт дурдсан ажлуудад болон монгол хэл, бичиг үсгээ сурч судлах, өвлөх, өвлүүлэх, эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх талаар идэвх санаачилга гарган ажиллахыг иргэд, олон нийт, эрдэмтэн судлаачид, шинжлэх ухааны ба хэвлэл мэдээллийн байгууллага, төрийн ба төрийн бус байгууллагуудад уриалсугай. | Улсын хэмжээнд зохион байгуулагдсан Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлох судалгаанд нийт албан хаагчид хамрагдсан. Аймгийн хэлний бодлогын салбар зөвлөлийн шийдвэрээр “ Монгол бичгээ эхлэн суралцах” цахим хичээлийг аймгийн хэмжээнд бүх төрийн албан хаагчдад явуулах зорилгоор “ДУНДГОВЬ АЙМГИЙН ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД” нэртэй фэйж хуудсанд элсэн монгол бичгийн цахим цуврал сургалтад хамрагдаж байна. Байгууллага бүрт монгол бичгийн багш хуваарилан хөтөлбөр сургалтын хуваарийн дагуу 7 хоногт 1 удаа хичээллэж байна. Монгол улсын гавъяат багш Д.Төмөрийн “Монгол бичгээ 15 хоногт бие даан сурах анхны хичээлүүд” номыг захиалан авч бичих дадлага хийж байна. УБЕГазраас зохион байгуулагдсан монгол бичгийн уралдаанд оролцлоо. | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 16 | 38 | Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58 | 2. Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай. | Зам дагуух тарьсан модоо хог шороог нь цэвэрлэж усалж эхлээд байна. | | | |
| **ЗГ-ын албан даалгавар** | | | | | | | |
| 40 | 80 | Төрийн үйлчилгээнд цахим төлбөр тооцоог нэвтрүүлэх тухай 2019-10-16 Дугаар 2019_03 | 1.5. Төрийн үйлчилгээнд цахим төлбөр тооцоог нэвтрүүлэхтэй холбогдуулан шаардлагатай бол эрхлэх асуудлын хүрээнд болон нутаг дэвсгэрийн хэмжээнд мөрдөж байгаа эрх зүйн актуудад зохих өөрчлөлт оруулах | Бүртгэлийн үйлчилгээний төлбөрийн Гэрэгэ системийг Дэрэн, Эрдэнэдалай сумд 2023 онд үйлчилгээнд нэвтрүүллээ. Мөн Сайнцагаан сумын улсын бүртгэгч дээр төлбөрийн пос машин байршуулсан нь үйлчилгээний шат дамжлага буурсан, цаг хугацаа зардал хэмнэсэн үйлчилгээ болж байна.Төлбөрийн цахим системээр 1600 иргэн үйлчлүүлсэн байна. | | | |